

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/2460 дугаар
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

**ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

2024 он



БАТЛАВ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРБЫН ТАМГЫН ГАЗРЫН

ДАРГА

Д.ТӨМӨРБААТАР

2024 оны 09 дүгээр сарын 18

а/в - 33

**ХОРООДЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ
АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер
шалгаруулалтын
нэр:

Хороодын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх ажил

Тендер
шалгаруулалтын
дугаар:

СХДХААА/20240103176

2024 он

1.1.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

1.2.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

1.3.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

2. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

2.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

2.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

2.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

2.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

2.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б. АГУУЛГА

3. Тендер шалгаруулалтын баримт бичиг

3.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

3.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

4. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

4.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

4.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

4.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

4.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

4.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 6-д заасныг мөрдөнө.

5. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

5.1.Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

5.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

5.3.ТШЗ-ны 5.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

6. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

6.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

6.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

7. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

7.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

7.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

7.3. Хэрэв ТШЗ-ны 7.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

7.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө

хариуцна.

8. Тендерийн иж бүрдэл

8.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

8.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

8.2.1. ТШЗ-ны 9-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

8.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

8.2.3. ТШЗ-ны 10-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

8.2.4. оролцогч ТШЗ-ны 11-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

8.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 12, 13, 14-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

8.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 15-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

8.2.7. ТШЗ-ны 16-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

8.2.8. ТШЗ-ны 16.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

8.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

8.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

8.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

9. Тендерийн жишиг маягтууд

9.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

10. Хувилбарт санал

10.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

11. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

11.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадлана. Үүнд:

11.1.1. ТШЗ-ны 9.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

11.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

11.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

11.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

11.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

11.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

11.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 11.1, 11.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

11.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 11.1, 11.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

12. Чадавхын болон туршлагын шаардлага

12.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

12.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

12.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

12.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

12.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

13. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

13.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

13.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

13.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

13.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн

байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

14. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

14.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

14.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

14.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

14.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

15. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

15.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

15.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

15.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

16. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

16.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

16.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

16.3. Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

16.4. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

16.5. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний

хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

17. Тендерийн валют

17.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

18. Тендер хүчинтэй байх хугацаа

18.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

18.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 18.1-д заасан хугацааг сунгаж болно.

18.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 19-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

18.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

19. Тендерийн баталгаа

19.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

19.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

19.2.1. ТШЗ-ны 18-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

19.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

19.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

19.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

19.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

20. Тендер баталгаажуулах, илгээх

20.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 19-т зааснаар илгээнэ.

20.2. ТШЗ-ны 20.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх

бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

20.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 20.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

20.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

20.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 20.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

21. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

21.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

21.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

22. Тендерийн талаар тодруулга авах

22.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

23. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

23.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 8-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

24. Тендерийг үнэлэх

24.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

25. Арифметик алдааг залруулах

25.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

26. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

26.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

27. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

27.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

- 27.1.1. ТШЗ-ны 16.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
 - 27.1.2. ТШЗ-ны 16.3-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
 - 27.1.3. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
 - 27.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 17.1-д заасан валютад хөрвүүлэх;
 - 27.1.6. ТШЗ-ны 26.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 27.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
- 27.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
 - 27.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 29-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
 - 27.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 27.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 27.4. ТШЗ-ны 27.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 28. Тендерийг эрэмбэлэх**
- 28.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 29. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 29.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног

төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

29.2. ТШЗ-ны 29.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 13.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 14.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

29.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

30. Мэдэгдэл хүргүүлэх

30.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

31. Гүйцэтгэлийн баталгаа

31.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

31.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

32. Урьдчилгаа төлбөр

32.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

33. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

33.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

33.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

33.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 33.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

33.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

34. Тендер шалгаруулалтын гомдол

34.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Хороодын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх ажил
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: СХДХААА/20240103176
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Тийм” Багц-1 (32, 33-р хороод) Багц-2 (16, 17, 30-р хороод) Багц-3 (10-р хороо)
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Дүүргийн хот тохижуулах зардлаас
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 2,072,545,338 (Хоёр тэрбум далан хоёр сая таван зуун дөчин таван мянга гурван зуун гучин найм) төгрөг Багц-1 (32, 33-р хороод) төсөвт өртөг: 1,241,916,540 (Нэр тэрбум хоёр зуун дөчин нэгэн сая есөн зуун арван зургаан мянга таван зуун дөч) төгрөг Багц-2 (16, 17, 30-р хороод) төсөвт өртөг: 409,537,718 (Дөрвөн зуун есөн сая таван зуун гучин долоон мянга долоон зуун арван найм) төгрөг Багц-3 (10-р хороод) төсөвт өртөг: 421,091,080 (Дөрвөн зуун хорин нэгэн сая ерэн нэгэн мянга ная) төгрөг Жич: Тендерт оролцогч нэг багцад санал ирүүлэх ба 2 багцад зэрэг санал ирүүлэхгүй.
Б. АГУУЛГА	
ТШЗ 4.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба Хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, Баянголын 1 дүгээр гудамж, 3 давхарт, 302 тоот Нутгийн захиргааны нэгдсэн байр, Худалдан авах ажиллагааны алба Утасны дугаар: 7000 0771, 7000 0717 Цахим шуудангийн хаяг: haaashd24@gmail.com <i>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт</i>

	<p>оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим системд дэх тендерийн урилгын тодруулга мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
ТШЗ 5.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 7.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 11.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <p>1.Тендер илгээх маягыг V бүлгийн Маягт 1-ийн дагуу бэлтгэсэн хуулийн 7.2-т заасан мэдэгдэл ирүүлнэ. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</p> <p>2.Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.</p> <p>3.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана.</p> <p>Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: Шаардлагатай.</p> <p>4.Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.</p>
ТШЗ 13.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <p>1.Борлуулалтын орлогын хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Багц-1 (32, 33-р хороод): Сүүлийн 3 жилд буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд борлуулалтын орлого нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 20 хувь буюу 248,383,308 төгрөгөөс багагүй байна. • Багц-2 (16, 17, 30-р хороод): Сүүлийн 3 жилд буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд борлуулалтын орлого нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувь буюу 163,815,087 төгрөгөөс багагүй байна.

	<ul style="list-style-type: none"> • Багц-3 (10-р хороод) : Сүүлийн 3 жилд буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд борлуулалтын орлого нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувь буюу 168,436,432 төгрөгөөс багагүй байна. <p>2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 20 хувиас багагүй байна. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; • Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт; • Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд; <p>(Банкны судлан үзэх болон шаардлага хангасан тохиолдолд зээл олгох боломжтой тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй)</p> <p>3. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)</p>																				
<p>ТШЗ 13.2</p>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p>Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа:</p> <p>Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2021, 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>(Тендерт оролцогчийн ирүүлсэн санхүүгийн тайланг үнэлгээнд харгалзан үзэхгүй.)</p>																				
<p>ТШЗ 14.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: “Шаардана”</p> <p>МАЯГТ 4-н дагуу инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж ирүүлнэ.</p> <p>Багц-1 (32, 33-р хороод)</p> <table border="1" data-bbox="448 1839 1485 2054"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Тоо</th> <th>Ажилласан жил</th> <th>Тайлбар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Гэрээний мэргэжилтэн</td> <td>2</td> <td>1</td> <td>Хороо тус бүр багадаа нэг гэрээний мэргэжилтэн байна.</td> </tr> <tr> <td>2</td> <td>Механик инженер</td> <td>1</td> <td>1</td> <td>Бусад багцад давхардаж болно</td> </tr> <tr> <td>3</td> <td>ХАБЭАА</td> <td>1</td> <td>1</td> <td></td> </tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Тоо	Ажилласан жил	Тайлбар	1	Гэрээний мэргэжилтэн	2	1	Хороо тус бүр багадаа нэг гэрээний мэргэжилтэн байна.	2	Механик инженер	1	1	Бусад багцад давхардаж болно	3	ХАБЭАА	1	1	
№	Албан тушаал	Тоо	Ажилласан жил	Тайлбар																	
1	Гэрээний мэргэжилтэн	2	1	Хороо тус бүр багадаа нэг гэрээний мэргэжилтэн байна.																	
2	Механик инженер	1	1	Бусад багцад давхардаж болно																	
3	ХАБЭАА	1	1																		

4	Жолооч	5	Машин тус бүр 1 жолооч	Багц тус бүр багадаа 5 доошгүй жолоочтой
5	Ачигч	5	Машин тус бүр 1 ачигч	Багц тус бүр багадаа 5 доошгүй ачигч

Багц-2 (16, 17, 30-р хороод):

№	Албан тушаал	Тоо	Ажилласан жил	Тайлбар
1	Гэрээний мэргэжилтэн	3	1	Хороо тус бүр багадаа нэг гэрээний мэргэжилтэн байна.
2	Механик инженер	1	1	Бусад багцад давхардаж болно
3	ХАБЭАА	1	1	
4	Жолооч	10	Машин тус бүр 1 жолооч	Багц тус бүр багадаа 10 доошгүй жолоочтой
5	Ачигч	10	Машин тус бүр 1 ачигч	Багц тус бүр багадаа 10 доошгүй ачигч

Багц-3 (10-р хороод):

№	Албан тушаал	Тоо	Ажилласан жил	Тайлбар
1	Гэрээний мэргэжилтэн	1	1	Хороо тус бүр багадаа нэг гэрээний мэргэжилтэн байна.
2	Механик инженер	1	1	Бусад багцад давхардаж болно
3	ХАБЭАА	1	1	
4	Жолооч	4	Машин тус бүр 1 жолооч	Багц тус бүр багадаа 4 доошгүй жолоочтой
5	Ачигч	4	Машин тус бүр 1 ачигч	Багц тус бүр багадаа 4 доошгүй ачигч

Тухайн хороонд гэрээний мэргэжилтнээр томилсон шийдвэр ирүүлэх.
(Гэрээний мэргэжилтэн ямарч төрлийн мэргэжилтэй байж болох бөгөөд тухайн байгууллагын үндсэн ажилтан байна.)

- Механик инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь гэрээт ажилтан байж болно. Жолооч, ачигч нарын 50 хувь нь үндсэн 50 хувь нь гэрээт ажилтан байж болно.

Гэрээт ажилтнаар ажиллуулах бол тухайн багц, төсөл арга хэмжээнд зориулан хөлсөөр ажиллуулах гэрээ ирүүлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны гэрчилгээтэй байна.

- Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, "Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем"-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. *"Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.*

- Гадаадын их, дээд сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлнэ.
- Дээрх инженер, техникийн ажилтан нарын Нийгмийн даатгалын шимтгэлийг 2024 оны 06, 07, 08 дугаар сарын тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуу
- лан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй.

Механик инженер 12 сар, гэрээний мэргэжилтэн 12 сар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан 12 сараар ажлын туршлагыг баталгаажуулахын тулд нийгмийн даатгал шимтгэл төлсөн лавлагаа ирүүлнэ.

Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **“Шаардана”**

Багц-1 (32, 33-р хороод)

№	Авто машины зориулалт	Техникийн хүчин чадал	Тоо ширхэг
1	Задгай тэвштэй хог тээвэрлэх машин	4.5тн болон түүнээс дээш	Хороо тус бүр 5-с доошгүй

1. Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтын дагуу бөглөж ирүүлнэ. (машин механизмууд нь үзлэг оношилгоонд бүрэн хамрагдсан байх)
2. Нийт 5 ширхэг машинаас 2 машиныг түрээсээр ашиглаж болно.
Бусад багцад давхардахгүй байна.
3. Түрээсийн гэрээг тендер зарласан өдрөөс хойш зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад асуудлыг тодорхой тусгасан байх.
4. Санал болгож буй машин механизмын тээврийн хэрэгслийн дугаар, холбогдох мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийн холбогдох талбарт бичиж санал болгоно.
5. Төсөлд ашиглах машин механизм, багаж хэрэгсэл нь фото зураг, гэрчигээний хуулбарыг ирүүлнэ. Хуулбар нь тод гаргацтай байна.
6. (Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан шалгана.)

Багц-2 (16, 17, 30-р хороод):

№	Авто машины зориулалт	Техникийн хүчин чадал	Тоо ширхэг
1	Хог хаягдлыг шахаж нягтруулан ачих машин	4.5м3 болон түүнээс дээш	16,17-р хороодод тус бүр 2-оос доошгүй
2	Задгай тэвштэй хог тээвэрлэх машин	4.5тн болон түүнээс дээш	30 дугаар хороонд 6-аас доошгүй

1. Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтын дагуу бөглөж ирүүлнэ. (машин механизмууд нь үзлэг оношилгоонд бүрэн хамрагдсан байх)
2. Нийт 8 ширхэг машинаас 4 машиныг түрээсээр ашиглаж болно. **Бусад багцад давхардахгүй байна.**
3. Түрээсийн гэрээг тендер зарласан өдрөөс хойш зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад асуудлыг тодорхой тусгасан байх.
4. Санал болгож буй машин механизмын тээврийн хэрэгслийн дугаар, холбогдох мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийн холбогдох талбарт бичиж санал болгоно.
5. Төсөлд ашиглах машин механизм, багаж хэрэгсэл нь фото зураг, гэрчигээний хуулбарыг ирүүлнэ. Хуулбар нь тод гаргацтай байна.
6. (Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан шалгана.)

Багц-3 (10-р хороод):

№	Авто машины зориулалт	Техникийн хүчин чадал	Тоо ширхэг
1	Задгай тэвштэй хог тээвэрлэх машин	4.5тн болон түүнээс дээш	10 дугаар хороонд 4-өөс доошгүй

1. Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтын дагуу бөглөж ирүүлнэ. (машин механизмууд нь үзлэг оношилгоонд бүрэн хамрагдсан байх)
2. Нийт 4 ширхэг машинаас 2 машиныг түрээсээр ашиглаж болно. **Бусад багцад давхардахгүй байна.**
3. Түрээсийн гэрээг тендер зарласан өдрөөс хойш зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад асуудлыг тодорхой тусгасан байх.
4. Санал болгож буй машин механизмын тээврийн хэрэгслийн дугаар, холбогдох мэдээллийг Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийн холбогдох талбарт бичиж санал болгоно.
5. Төсөлд ашиглах машин механизм, багаж хэрэгсэл нь фото зураг, гэрчигээний хуулбарыг ирүүлнэ. Хуулбар нь тод гаргацтай байна.
6. (Дээрх машин механизмын эзэмшигчийн талаарх мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан шалгана.)

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: **“Шаардана”**

	<p>Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: Тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 20 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр доод тал нь нэг удаа ажилласан байх.</p> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээ үзүүлсэн гэрээний хуулбар; • Тухайн үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. <p><i>Ижил төстэй ажилд хог тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлсэн туршлагыг тооцно</i></p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардахгүй”</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”</p>
<p>ТШЗ 14.2</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <p>Жич: Тендерт оролцогч нэг багцад санал ирүүлэх ба 2 багцад зэрэг санал ирүүлэхгүй.</p> <ol style="list-style-type: none"> 1. Хог тээврийн үйлчилгээ үзүүлэхдээ календарчилсан төлөвлөгөөг боловсруулж ирүүлнэ. (НИТХ-ын 32/03 дугаар журам мөрдлөг болгоно.) 2. Хог ачилтыг байгууллага нь тухайн хорооны гудамж, талбай, гуу жалга, замыг судлах зорилгоор хороон дээр очиж танилцаж, тухай хорооны засаг даргын тодорхойлолт ирүүлэх, фото зургаар баталгаажуулан ирүүлнэ. 3. Ажлын даалгаврын Үндсэн шаардлага хэсэгт тусгагдсан шаардлагыг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, зургийг ирүүлнэ. <i>(Ажлын даалгавраас зөрсөн эсвэл дээрх шаардлагыг хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.)</i> 4. Тухайн байгууллага нь өөрийн эзэмшлийн эсвэл түрээсийн засварын төв, дулаан граш, авто баазтай байх ба нотлох зураг, тайлбар, түрээсийнх бол түрээсийн гэрээ ирүүлнэ. 5. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, календарчилсан төлөвлөгөө, тээвэрлэх графикт багтаан үйлчилгээг чанартай гүйцэтгэх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ. 6. Эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлын хангах байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай ногоон орчныг бүрдүүлэх тухай мэдэгдэл ирүүлнэ. 7. Хотын стандарт UCS 1701A:2022 Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент, UCS 1705A:2022 Хог хаягдлын устгалын стандарт устгалын удирдамж, UCS 1706A:2022 Барилгын хог хаягдалын менежментийг баримтлан ажиллах албан мэдүүлэг ирүүлнэ.

	<i>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно.</i>
ТШЗ 14.3	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана” Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлснийг нотлох баримт
ТШЗ 16.4	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 19.1	Тендерийн баталгааны дүн: Шаардана. Багц-1 (32, 33-р хороод): 6,209,583 төгрөг Багц-2 (16, 17, 30-р хороод): 2,047,689 төгрөг Багц-3 (10-р хороод): 2,105,455 төгрөг Хүчинтэй байх хугацаа: Тендерийн хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 20.5	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт 7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ. Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.
ТШЗ 21.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 10 сарын 10-ны өдөр Цаг: 09 цаг 00 минут Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.
ТШЗ 21.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 10 сарын 10-ны өдөр Цаг: 09 цаг 10 минут Тендер нээх газрын хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, Баянголын 1 дүгээр гудамж, 3 давхарт, 302 тоот Нутгийн захиргааны нэгдсэн байр, Худалдан авах ажиллагааны алба

Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 26.1	<p>Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: <i>[хуулийн 11.4.2, 11.4.3-т заасан шалгуурыг хэрэглэхээс бусад тохиолдолд “Үгүй” гэж бич.]</i></p> <p><i>Хэрэв “Ашиглах” бол IV бүлгийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтээс аль тохирохыг сонгож бичнэ үү.]</i></p>
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 31.1	<p>Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Туйм”</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсгийг дагуу Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ</p>

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Үйлчилгээний даалгаврыг хавсаргана уу.]

БАТЛАВ
 СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ
 ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 Д.ТӨМӨРБААТАР

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 32, 33 ДУГААР ХОРООДЫН АЙЛ ӨРХ, АЖ
 АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАН ТЭЭВЭРЛЭЛТ
 ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 09 өдөр	Дугаар №01	Улаанбаатар хот
1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 10/01 дугаар тогтоол
2	Захиалагч байгууллага	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
3	Ерөнхий шаардлага	Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор дүүргийн хорооны нутаг дэвсгэр дэх айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх
4	Байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ	Сонгинохайрхан дүүргийн 32, 33 дугаар хороод
5	Үндсэн шаардлага	1.Энгийн хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, задгай тэвштэй болон шахдаг тээврийн хэрэгслээр тээвэрлэх 2.Тээвэрлэх хог хаягдлын төрөл, ангиллыг заасан тэмдэг тэмдэглэгээтэй байна. 3.Батлагдсан маршрут, хуваарийн дагуу тээвэрлэнэ. 4.Хог хаягдлыг тээвэрлэх график, маршрутыг жил, улирлаар гаргаж, хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан ажиллана. 5.Тухайн бүсийн нутаг дэвсгэрт үүссэн ил задгай хог хаягдлыг бүрэн цэвэрлэх, ил задгай хоггүй байлгах 6.Гэр хорооллын хог хаягдал тээвэрлэх автомашин нь хог бүтээх бүтээлэгтэй байх 7.Байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрийн хог хаягдлыг хог хаягдлын бүтэц онцлогт тохирсон хог тээврийн зориулалттай автомашинаар тээвэрлэх 8.Хог ачиж, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг үзүүлэхдээ харилцаа, хандлагын доголдол гаргахгүй байх 9.Хог хаягдлыг ачиж цуглуулахдаа ил задгай хог хаягдал үүсгэхгүй байна. 10.Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд ажиллахдаа ХАБЭА-ын болон бусад хууль, дүрэм журам, стандартыг мөрдлөг болгох, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, багаж хэрэгслэлийг бүрэн бүрдүүлж, ХАБЭА аюулгүйн ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах /хамгаалалтын малгай, цацруулагч, байгууллагын лого, ажилтны нэр бүхий ажлын хувцас, бээлий, маск, хамгаалалттай ажлын гутал, хамгаалалтын нүдний шил, хүрз г.м/ 11.Хариуцсан бүсийн хог хаягдлыг тээвэрлэхдээ тухайн бүсийн үйлчилгээ үзүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллах орон тооны


		ажилтантай байх /Хороо бүрт багадаа 1 ажилтан/ 12.Батлагдсан төсвийн 2 хувиас хэтрэхгүй мөнгөн дүнг хог хаягдлын тухай хууль болон холбогдох дүрэм журмыг сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулна. /Төлөвлөгөөнд тусгах/ 13.Ангилсан хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын машин 1-ээс доошгүй байх															
6	Зориулалт хүчин чадал, хүн амын тоо	32 дугаар хороо-Хорооны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг цуглуулан тээвэрлэлт хийх /Өрхийн тоо-1657, хүн амын тоо-4812, ААНБ-ын тоо-72/ 33 дугаар хороо-Хорооны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг цуглуулан тээвэрлэлт хийх /Өрхийн тоо-3651, хүн амын тоо-12908, ААНБ-ын тоо-000 /															
7	Хог тээвэрлэх хуваарь	32 дугаар хороо – 1 сарын хугацаанд Задгай тэвштэй 5 машинаар тээвэрлэлт хийх 33 дугаар хороо – 1 сарын хугацаанд Задгай тэвштэй 5 машинаар тээвэрлэлт хийх															
8	Онцгой нөхцөл	1.Багцад хамаарч байгаа хог тээврийн үйлчилгээг үзүүлэхдээ доод тал нь 4 машинтай байна. 2. Хог тээврийн үйлчилгээг үзүүлэхдээ календарчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна. 3. 15 хороодын 75.000-80.000 тонн хүртэлх хог хаягдал цуглуулж тээвэрлэх төсөвт үнийн санал ирүүлсэн байх															
9	Шаардагдах техникийн үзүүлэлт	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th colspan="2">Техникийн үзүүлэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Зориулалт</td> <td>1.Хуурай хог хаягдлыг шахаж нягтруулан ачих машин 2. Задгай тэвштэй хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын автомашин</td> </tr> <tr> <td>2</td> <td>Үйлдвэрлэсэн улс</td> <td>Сайн чанрын эдэлгээ сайтай 2018 оноос хойш үйлдвэрлэсэн байх</td> </tr> <tr> <td>3</td> <td>Техникийн хүчин чадал /Задгай тэвштэй/</td> <td>4,5 тн-оос дээш байх</td> </tr> <tr> <td>4</td> <td>Техникийн хүчин чадал /Шахдаг/</td> <td>4,5 кубээс дээш байх</td> </tr> </tbody> </table>	№	Техникийн үзүүлэлт		1	Зориулалт	1.Хуурай хог хаягдлыг шахаж нягтруулан ачих машин 2. Задгай тэвштэй хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын автомашин	2	Үйлдвэрлэсэн улс	Сайн чанрын эдэлгээ сайтай 2018 оноос хойш үйлдвэрлэсэн байх	3	Техникийн хүчин чадал /Задгай тэвштэй/	4,5 тн-оос дээш байх	4	Техникийн хүчин чадал /Шахдаг/	4,5 кубээс дээш байх
№	Техникийн үзүүлэлт																
1	Зориулалт	1.Хуурай хог хаягдлыг шахаж нягтруулан ачих машин 2. Задгай тэвштэй хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын автомашин															
2	Үйлдвэрлэсэн улс	Сайн чанрын эдэлгээ сайтай 2018 оноос хойш үйлдвэрлэсэн байх															
3	Техникийн хүчин чадал /Задгай тэвштэй/	4,5 тн-оос дээш байх															
4	Техникийн хүчин чадал /Шахдаг/	4,5 кубээс дээш байх															

ХЯНАСАН: ТНААХ-ИЙН ДАРГА



Ж.НЯМХҮҮ

БОЛОВСРУУЛСАН МЭРГЭЖИЛТЭН



Ц.ЧИМЭДБАЛДИР

БАТЛАВ.
 СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ
 ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 Д.ТӨМӨРБААТАР


СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 16, 17, 30 ДУГААР ХОРООДЫН АЙЛ ӨРХ, АЖ
 АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАН ТЭЭВЭРЛЭЛТ
 ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 09 өдөр	Дугаар № 02	Улаанбаатар хот
1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоол Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 10/01 дугаар тогтоол
2	Захиалагч байгууллага	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар
3	Ерөнхий шаардлага	Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор дүүргийн хорооны нутаг дэвсгэр дэх айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх
4	Байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ	Сонгинохайрхан дүүргийн 16, 17, 30 дугаар хороод
5	Үндсэн шаардлага	1.Энгийн хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, задгай тэвштэй болон шахдаг тээврийн хэрэгслээр тээвэрлэх 2.Тээвэрлэх хог хаягдлын төрөл, ангиллыг заасан тэмдэг тэмдэглэгээтэй байна. 3.Батлагдсан маршрут, хуваарийн дагуу тээвэрлэнэ. 4.Хог хаягдлыг тээвэрлэх график, маршрутыг жил, улирлаар гаргаж, хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан ажиллана. 5.Тухайн бүсийн нутаг дэвсгэрт үүссэн ил задгай хог хаягдлыг бүрэн цэвэрлэх, ил задгай хоггүй байлгах 6.Гэр хорооллын хог хаягдал тээвэрлэх автомашин нь хог бүтээх бүтээлэгтэй байх 7.Байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрийн хог хаягдлыг хог хаягдлын бүтэц онцлогт тохирсон хог тээврийн зориулалттай автомашинаар тээвэрлэх 8.Хог ачиж, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг үзүүлэхдээ харилцаа, хандлагын доголдол гаргахгүй байх 9.Хог хаягдлыг ачиж цуглуулахдаа ил задгай хог

		<p>хаягдал үүсгэхгүй байна.</p> <p>10.Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд ажиллахдаа ХАБЭА-ын болон бусад хууль, дүрэм журам, стандартыг мөрдлөг болгох, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, багаж хэрэгслэлийг бүрэн бүрдүүлж, ХАБЭА аюулгүйн ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах /хамгаалалтын малгай, цацруулагч, байгууллагын лого, ажигтны нэр бүхий ажлын хувцас, бээлий, маск, хамгаалалттай ажлын гутал, хамгаалалтын нүдний шил, хүрз г.м/</p> <p>11.Хариуцсан бүсийн хог хаягдлыг тээвэрлэхдээ тухайн бүсийн үйлчилгээ үзүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллах орон тооны ажилтантай байх /Хороо бүрт багадаа 1 ажилтан/</p> <p>12.Батлагдсан төсвийн 2 хувиас хэтрэхгүй мөнгөн дүнг хог хаягдлын тухай хууль болон холбогдох дүрэм журмыг сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулна. /Төлөвлөгөөнд тусгах/</p> <p>13.Ангилсан хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын машин 1-ээс доошгүй байх</p>
6	Зориулалт хүчин чадал, хүн амын тоо	<p>16 дугаар хороо- Хорооны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг цуглуулан тээвэрлэлт хийх /Өрхийн тоо-1509, Байнгын оршин суугч 5954, Түр оршин суугч 566, Хүн амын тоо- 6520</p> <p>17 дугаар хороо- Хорооны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг цуглуулан тээвэрлэлт хийх /Өрхийн тоо-1517, Байнгын оршин суугч 5626, Түр оршин суугч 21, Хүн амын тоо- 5647</p> <p>30 дугаар хороо- Хорооны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг цуглуулан тээвэрлэлт хийх /Өрхийн тоо-1401, Байнгын оршин суугч 5713, Түр оршин суугч 54, Хүн амын тоо- 5757</p>
7	Хог тээвэрлэх хуваарь	<p>16 дугаар хороо – 1 сарын хугацаанд Шахдаг 1-2 автомашинаар тээвэрлэлт хийх</p> <p>17 дугаар хороо – 1 сарын хугацаанд Шахдаг 1-2 автомашинаар тээвэрлэлт хийх</p> <p>30 дугаар хороо – 1 сарын хугацаанд айл өрхийн хог хаягдлыг 2 удаагийн давтамжтай , 6 автомашинаар тээвэрлэлт хийх</p>
8	Онцгой нөхцөл	<p>1.Багцад хамаарч байгаа хог тээврийн үйлчилгээг үзүүлэхдээ доод тал нь 5 машинтай байна.</p> <p>2. Хог тээврийн үйлчилгээг үзүүлэхдээ календарчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна.</p>


9	Шаардагдах техникийн үзүүлэлт	Техникийн үзүүлэлт		
		№		
		1	Зориулалт	1.Хуурай хог хаягдлыг шахаж нягтруулан ачих машин 2. Задгай тэвштэй хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын авто машин
		2	Үйлдвэрлэсэн улс	Сайн чанарын эдэлгээ сайтай 2018 оноос хойш үйлдвэрлэсэн байх
		3	Техникийн хүчин чадал /Задгай тэвштэй/	4,5 тн-оос дээш байх
4	Техникийн хүчин чадал /Шахдаг/	4,5 кубээс дээш байх		

ХЯНАСАН: ТНААХ-ИЙН ДАРГА




Ж.НЯМХҮҮ

БОЛОВСРУУЛСАН МЭРГЭЖИЛТЭН



Ц.ЧИМЭДБАЛДИР



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРООНЫ АЙЛ ӨРХ, АЖ АХУЙН
 НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАН ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙХ
 АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 09 өдөр		Дугаар № 03	Улаанбаатар хот
1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалт Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 10/01 дугаар тогтоол	
2	Захиалагч байгууллага	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар	
3	Ерөнхий шаардлага	Хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор дүүргийн хорооны нутаг дэвсгэр дэх айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх	
4	Байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ	Сонгинохайрхан дүүргийн 10 хороо	
5	Үндсэн шаардлага	1.Энгийн хог хаягдлыг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, задгай тэвштэй болон шахдаг тээврийн хэрэгслээр тээвэрлэх 2.Тээвэрлэх хог хаягдлын төрөл, ангиллыг заасан тэмдэг тэмдэглэгээтэй байна. 3.Батлагдсан маршрут, хуваарийн дагуу тээвэрлэнэ. 4.Хог хаягдлыг тээвэрлэх график, маршрутыг жил, улирлаар гаргаж, хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан ажиллана. 5.Тухайн бүсийн нутаг дэвсгэрт үүссэн ил задгай хог хаягдлыг бүрэн цэвэрлэх, ил задгай хоггүй байлгах 6.Гэр хорооллын хог хаягдал тээвэрлэх автомашин нь хог бүтээх бүтээлэгтэй байх 7.Байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрийн хог хаягдлыг хог хаягдлын бүтэц онцлогт тохирсон хог тээврийн зориулалттай автомашинаар тээвэрлэх 8.Хог ачиж, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг үзүүлэхдээ харилцаа, хандлагын доголдол гаргахгүй байх 9.Хог хаягдлыг ачиж цуглуулахдаа ил задгай хог хаягдал үүсгэхгүй байна. 10.Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх	

		<p>үйлчилгээнд ажиллахдаа ХАБЭА-ын болон бусад хууль, дүрэм журам, стандартыг мөрдлөг болгох, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, багаж хэрэгслэлийг бүрэн бүрдүүлж, ХАБЭА аюулгүйн ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах /хамгаалалтын малгай, цацруулагч, байгууллагын лого, ажилтны нэр бүхий ажлын хувцас, бээлий, маск, хамгаалалттай ажлын гутал, хамгаалалтын нүдний шил, хүрээ г.м/</p> <p>11.Хариуцсан бүсийн хог хаягдлыг тээвэрлэхдээ тухайн бүсийн үйлчилгээ үзүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажиллах орон тооны ажилтантай байх</p> <p>12.Батлагдсан төсвийн 2 хувиас хэтрэхгүй мөнгөн дүнг хог хаягдлын тухай хууль болон холбогдох дүрэм журмыг сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулна. /Төлөвлөгөөнд тусгах/</p> <p>13.Ангилсан хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын машинтай байх</p>															
6	Зориулалт хүчин чадал, хүн амын тоо	Хорооны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг цуглуулан тээвэрлэлт хийх /Өрхийн тоо-2515, байнгын оршин суугч 10087, Түр оршин суугч 210, Хүн амын тоо 10297 /															
7	Хог тээвэрлэх хуваарь	1 сарын хугацаанд айл өрхийн хог хаягдлыг 2 удаагийн давтамжтай ачиж, Задгай тэвштэй 4 машинаар тээвэрлэлт хийх															
8	Онцгой нөхцөл	1.Багцад хамаарч байгаа хог тээврийн үйлчилгээг үзүүлэхдээ доод тал нь 5 машинтай байна. 2. Хог тээврийн үйлчилгээг үзүүлэхдээ календарчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна.															
9	Шаардагдах техникийн үзүүлэлт	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th colspan="2">Техникийн үзүүлэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Зориулалт</td> <td>1. Задгай тэвштэй хог хаягдлыг тээвэрлэх машин</td> </tr> <tr> <td>2</td> <td>Үйлдвэрлэсэн улс</td> <td>Сайн чанарын эдэлгээ сайтай 2018 оноос хойш үйлдвэрлэсэн байх</td> </tr> <tr> <td>3</td> <td>Техникийн хүчин чадал /Задгай тэвштэй/</td> <td>4,5 тн-оос дээш байх</td> </tr> <tr> <td>4</td> <td>Техникийн хүчин чадал /Шахдаг/</td> <td>4,5 кубээс дээш байх</td> </tr> </tbody> </table>	№	Техникийн үзүүлэлт		1	Зориулалт	1. Задгай тэвштэй хог хаягдлыг тээвэрлэх машин	2	Үйлдвэрлэсэн улс	Сайн чанарын эдэлгээ сайтай 2018 оноос хойш үйлдвэрлэсэн байх	3	Техникийн хүчин чадал /Задгай тэвштэй/	4,5 тн-оос дээш байх	4	Техникийн хүчин чадал /Шахдаг/	4,5 кубээс дээш байх
№	Техникийн үзүүлэлт																
1	Зориулалт	1. Задгай тэвштэй хог хаягдлыг тээвэрлэх машин															
2	Үйлдвэрлэсэн улс	Сайн чанарын эдэлгээ сайтай 2018 оноос хойш үйлдвэрлэсэн байх															
3	Техникийн хүчин чадал /Задгай тэвштэй/	4,5 тн-оос дээш байх															
4	Техникийн хүчин чадал /Шахдаг/	4,5 кубээс дээш байх															

ХЯНАСАН: ТНААХ-ИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН МЭРГЭЖИЛТЭН

Ж.НЯМХҮҮ

Ц.ЧИМЭДБАЛДИР

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Үйлчилгээ дуусгах хугацаа: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

*Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бичих]**–аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.*

*Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас **[тоо бичих]**-аас илүү **[“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих]** хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]

*Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: [“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]

*Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх тендерийн харьцуулах үнийг тодорхойлж болно.

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид **“тендер”** гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].**
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь окууны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:
Хаяг:***

Маягт 2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

Маягт 7. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 10. Санал болгож буй ажилтны жишиг намтар (сv)

Санал болгож буй албан тушаал: _____

Овог, нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрт онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Маягт 11. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

Маягт 12. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

		Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.			
2.			
3.			
4.			
5.			

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. *Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:*

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- | | | | |
|------------------------|---------|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Захиалагчийн үүрэг | нийтлэг | 2.1. | Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө. |
| | | 2.2. | Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө. |
| | | 2.3. | Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч | | 2.4. | Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно. |
| | | 2.5. | Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| | | 2.6. | Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Талбайд зөвшөөрөл | нэвтрэх | 2.7. | Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно. |
| | | 2.8. | Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна. |

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | | | |
|---------------------|---------|------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Гүйцэтгэгчийн үүрэг | нийтлэг | 3.1. | Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө. |
| | | 3.2. | Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө. |
| | | 3.3. | Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна. |

- 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
- 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Аюулгүй байдал 3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- Ажил эхлэх 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын

- үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Хугацаа сунгах 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
- 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- Гэрээний үнэ 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
- 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

- | | | |
|-------------------|-------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Урьдчилгаа төлбөр | 5.4. | Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно. |
| | 5.5. | Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно. |
| Төлбөрийн нөхцөл | 5.6. | Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө. |
| | 5.7. | Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно. |
| | 5.8. | Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ. |
| | 5.9. | Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй. |
| | 5.10. | Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. |
| | 5.11. | Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана. |

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | | |
|-----------------------|------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Урьдчилгаа баталгаа | 6.1. | ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. | Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | 6.3. | Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна: <ul style="list-style-type: none"> 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | 6.4. | Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | 6.5. | ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |

- | | |
|-------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Чанарын баталгаа | <p>6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.</p> <p>6.7. Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.</p> <p>6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.</p> <p>6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> |
| Баталгаат хугацаа | <p>6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.</p> |

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- | | |
|-----------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Бусдад учруулсан хохирлыг арилгах | <p>7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p> |
| Захиалагчийн эрсдэл | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p> <p>7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;</p> <p>7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.</p> <p>7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.</p> |

- Даатгал
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- Доголдлыг арилгах илрүүлэх,
- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.
- Далд доголдол
- 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Зураг төслийн доголдол
- 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- Захиалагч гэрээг цуцлах
- 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;
 - 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
 - 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
 - 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
 - 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
 - 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
 - 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
 - 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- Гэрээг цуцлах журам
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан

- хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл 10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал 10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.

- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: Гэрээ хийгдсэнээс хойш 4 сар байна.
ГЕН 4.2.	Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: улирал, жилээр ирүүлэх
ГЕН 4.9.	Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Хийхгүй”
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй” Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: [мөнгөн дүн бич]
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: [ажлын хоног бичих]
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: [он, сар, өдөр] Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: [мөнгөн дүн бич] Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.7.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: “Шаардана” Чанарын баталгаа шаардах бол, Чанарын баталгааны хэмжээ: Гэрээний үнийн дүнгийн 5 хувь
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: 4 сар
ГЕН 7.5.	Даатгал: Үйлчилгээ үзүүлэх ажлаас гарч болох эрсдэлийг тодорхойлон гүйцэтгэгч тал даатгал бүрэн хариуцна.
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: 0
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: Гүйцэтгэгчид алданги ногдуулах хэмжээ хоногт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%-иас хэтрэхгүй байна.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
 - 3.7. Техникийн тодорхойлолт;
 - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 09 сарын 18**
Тендер шалгаруулалтын төрөл: Үйлчилгээ
Тендер шалгаруулалтын нэр: **Хороодын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: **СХДХААА/20240103176**
Нийт төсөвт өртөг: **2,072,545,338 (Хоёр тэрбум далан хоёр сая таван зуун дөчин таван мянга гурван зуун гучин найм) төгрөг**
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга** нь нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
 2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Туйм”**,
 - Багц-1 (32, 33-р хороод) төсөвт өртөг: 1,241,916,540 (Нэр тэрбум хоёр зуун дөчин нэгэн сая есөн зуун арван зургаан мянга таван зуун дөч) төгрөг
 - Багц-2 (16, 17, 30-р хороод) төсөвт өртөг: 409,537,718 (Дөрвөн зуун есөн сая таван зуун гучин долоон мянга долоон зуун арван найм) төгрөг
 - Багц-3 (10-р хороод) төсөвт өртөг: 421,091,080 (Дөрвөн зуун хорин нэгэн сая ерэн нэгэн мянга ная) төгрөг
 3. Тендерийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө тендерийн баримт бичигт заасан журмаар ирүүлэх ба тендерийн нээлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 09 цаг 10 минутад зохион байгуулна.
 4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
 5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
 6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
 7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Туйм”**
 - Багц-1 (32, 33-р хороод) төсөвт өртөг: 1,241,916,540 (Нэр тэрбум хоёр зуун дөчин нэгэн сая есөн зуун арван зургаан мянга таван зуун дөч) төгрөг
 - Багц-2 (16, 17, 30-р хороод) төсөвт өртөг: 409,537,718 (Дөрвөн зуун есөн сая таван зуун гучин долоон мянга долоон зуун арван найм) төгрөг
 - Багц-3 (10-р хороод) төсөвт өртөг: 421,091,080 (Дөрвөн зуун хорин нэгэн сая ерэн нэгэн мянга ная) төгрөг
 8. Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
 9. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
 10. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
 11. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.
- Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хороо, Нутгийн захиргааны нэгдсэн
байр, 3 давхар 302 тоот
Утас: 70000717, 7000771